


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар буюу **23-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 11 аймагт **1245** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ аван.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1245 тохиолдлын 94% /1174/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /71/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /4/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **342** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.


23 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.05.31 – 2026.06.06)


2026 оны хорин гуравдугаар долоо хоногт 11 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 450 хувиар өссөн бол 5 жилийн дунджаас 35.3 хувиар тус буурсан үзүүлэлттэй байна.

**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-23 дугаар долоо хоногт** нийт **761** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



2026 оны **хорин гуравдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **29** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 107 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (23-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	16	6	22
2	Эмийн хордлого	2	5	7
Нийт		18	11	29

Нийт 29 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 7 (24%) нь эмийн хордлого, 22 (76%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 11 (38%) тохиолдол, санаатай хордлого 18 (62%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-oOo-